



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 649

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баянчандмань-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 6 нэрийн нийт 226,272,791.00 (хоёр зуун хорин зургаан сая хоёр зуун далан хоёр мянга долоон зуун ерэн нэгэн) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 19,000,000.00 (арван есөн сая) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. “Баянчандмань-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Ренчиндамба, ерөнхий инженер бөгөөд гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн ...⁶⁴⁹ дугаар тогтоолын хавсралт

"БАЯНЧАНДМАНЬ-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр | Ашиг лалтад орсон огноо | Хэмж их нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Шинэчилсэн үнэ (төгрөг) | Цаашид ашиглах жил |
|---------------------------|--|-------------------------|--------------|------------|--|-------------------------|--------------------|
| 3 | 07-19 ТӨА улсын дугаартай Соната-6 маркийн суудлын автомашин | | ш | 1 | 24,951,542.00 | 1,000,000.00 | 1 |
| 1 | 21-66 УБС улсын дугаартай Автосамосвал маркийн автомашин | 2006 | ш | 1 | 33,383,349.00 | 1,500,000.00 | 1 |
| 2 | 98-94 УНЗ улсын дугаартай Бонго маркийн тээврийн хэрэгсэл | | ш | 1 | 13,000,000.00 | 1,000,000.00 | 1 |
| 4 | Экскаватор маркийн тээврийн хэрэгсэл | | ш | 1 | 325,600.00 | 100,000.00 | 1 |
| 5 | 98-94 УНЗ улсын дугаартай Бонго маркийн тээврийн хэрэгсэл | | ш | 1 | 104,780,700.00 | 6,400,000.00 | 1 |
| 6 | 98-94 УНЗ улсын дугаартай Бонго маркийн тээврийн хэрэгсэл | | ш | 1 | 49,831,600.00 | 10,000,000.00 | 1 |
| | | | | | 226,272,791.00 | 19,000,000.00 | - |
| ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН | | | | | (хоёр зуун хорин зургаан сая хоёр зуун далан хоёр мянга долоон зуун ерэн нэгэн) | (арван есөн сая) | |